



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2023/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДУА-2023/05/НА-СТА-ТТЗ

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	1
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
4. Аудитын тайлан	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	10
5. Аудитын илрүүлэлт	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	162

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
МХС	Мал хамгаадах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан

1.Аудиын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.АМАРТҮВШИН ТАНАА

2023.03.29

№

1462

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 59.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “**Түн өрмийн худгийн цооног гаргах**” ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж шууд худалдан авах гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн.
- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгч, төсөл хэрэгжүүлэгч 10 иргэн **24.4** сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 8.6, 8.7.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8, Төсвийн тухай хуулийн 16.5.2, Иргэний хуулийн 222.4, 222.5, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-дэх заалтуудтай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 189.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 5,448.8 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу

0012020282

бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2022 оны Б/333 дугаар бүхий үндэслэлгүй захирамжаар төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчид балансын урамшуулал олгосон зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байв. Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн чиглэлийн дагуу үндсэн чиг үүрэгт хамааралгүй, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан 20.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил нь удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 зорилт, 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 113 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,155,899.0	879,295.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	503,726.2	578,642.4
33	АВЛАГА	230,874.9	97,598.8
35	БАРАА МАТЕРИАЛ	410,847.9	193,053.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,450.0	10,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,649,897.5	840,481.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,649,897.5	840,481.0
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	5,583,954.6	837,873.4
39300	Биет бус хөрөнгө	65,942.9	2,607.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,805,796.6	1,719,776.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,257.2	3,960.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,257.2	3,960.6
41300	Өглөг	28,257.2	3,960.6
41400	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,777,539.4	1,715,815.5
51	Засгийн газрын хувь оролцоо	6,777,539.4	1,715,815.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,673,411.6	415,427.2
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.0	0.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,673,411.6	415,427.2
51200	Хуримтлагдсан үр дүн	3,817,476.5	1,200,984.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,286,651.2	99,404.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,805,796.6	1,719,776.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,945,343.4	1,201,800.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	263,188.9	386,891.1
110	Орлогын албан татвар	31,265.8	132,383.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	31,265.8	132,383.0
113	Хөрөнгийн албан татвар	55,445.3	78,679.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	176,477.8	175,828.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	748,511.4	117,566.3
120	Нийтлэг татварын бус орлого	748,381.4	117,566.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,933,643.1	697,342.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,401,648.2	855,526.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,401,648.2	855,526.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,545,586.2	500,865.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,171,307.6	210,045.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,157.9	26,043.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,099.8	10,083.2
2104	Хангамж, бараа материалын зардал	120,314.5	55,753.0
2105	Нормативт зардал	229,614.2	35.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,655.8	7,167.5
2107	Томилолт, зочны зардал	5,632.0	7,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,366.4	21,252.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	630,437.9	163,285.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	856,062.0	354,661.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	543,695.2	346,273.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	59,525.4	5,314,197.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	484,169.7	-4,967,923.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,293,369.6	6,293,369.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,293,369.6	6,293,369.6
9	Тайлант үеийн үр дүн	484,169.7	484,169.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,777,539.4	6,777,539.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,777,539.4	6,777,539.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-639,381.0	-639,381.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,138,158.4	6,138,158.4
19	Тайлант үеийн үр дүн	-4,967,923.6	-4,967,923.6
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,715,815.5	1,715,815.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,218,496.7	1,112,016.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	263,188.9	386,891.1
110	Орлогын албан татвар	31,265.8	132,383.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	31,265.8	132,383.0
113	Хөрөнгийн албан татвар	55,445.3	78,679.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	176,477.8	175,828.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,922.9	6,320.1
1181	Газрын төлбөр	2,290.9	12,358.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	166,264.0	157,150.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,382.0	82,683.9
120	Нийтлэг татварын бус орлого	124,252.0	82,683.9
121	Хөрөнгийн орлого	130.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,830,925.7	642,441.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,773,424.8	714,360.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,773,424.8	714,360.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,911,352.9	640,175.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,152,226.5	253,326.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,157.9	31,590.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,884.8	183,921.5
2104	Хангамж, бараа материалын зардал	113,513.9	33,207.7
2105	Нормативт зардал	132,065.4	35.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,722.1	22,174.8
2107	Томилолт, зочны зардал	5,632.0	7,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,065.0	20,851.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,085.2	87,868.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	862,072.0	74,185.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	445,071.9	397,655.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	159,151.5	322,739.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	159,151.5	322,739.4
2200	Дотоод эх үүсвэрээр	159,151.5	322,739.4
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-159,151.5	-322,739.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	285,920.3	74,916.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	217,805.9	503,726.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	503,726.2	578,642.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,435,549.7	966,292.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,838.9	647,403.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	822,959.3	616,742.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,886.2	253,326.5
210101	Үндсэн цалин	205,883.2	197,756.7
210102	Нэмэгдэл	44,507.0	38,416.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	22,496.0	17,153.0
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,907.4	31,590.4
210201	Тэтгэврийн даатгал	26,628.6	21,710.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,078.7	2,403.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,454.5	2,107.9
210204	Ажилгүйдлийн даатгал	606.5	470.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6,139.1	4,898.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,705.9	183,652.9
210301	Гэрэл, цахилгаан	15,688.0	14,722.7
210302	Түлш, халаалт	168,922.3	166,202.1
210303	Цэвэр, бохир ус	3,095.6	2,728.0
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	34,217.0	30,445.1
210401	Бичиг хэрэг	2,681.5	2,453.4
210402	Тээвэр, шатахуун	22,412.1	19,957.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,243.4	2,243.4
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,240.0	2,996.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,640.0	2,795.1
2105	Нормативт зардал	90.0	35.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.0	35.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,589.1	25,219.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000.0	3,849.7
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	21,589.1	21,369.9
2107	Томилолт, зочны зардал	7,240.0	7,200.0
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	7,240.0	7,200.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,353.6	13,681.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,160.0	12,532.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	222.4	222.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123.2	123.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720.0	720.0
210807	Газрын төлбөр	83.0	82.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	239,970.1	71,591.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	235,954.1	70,264.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,016.0	1,327.2
211	ХҮҮ	-	-
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
212	ТАТААС	-	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,879.6	30,660.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,879.6	30,660.9
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,300.0	3,300.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,333.2	14,114.5
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,626.4	12,626.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620.0	620.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	417,760.8	318,889.7
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
223001	Бусад хөрөнгө	417,760.8	318,889.7
224001	Стратегийн нөөц хөрөнгө	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	163,950.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	163,950.0	-
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	-	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,435,549.7	1,112,939.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	146,981.5	146,981.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-
310002	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	146,981.5	146,981.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	940,797.2	907,503.0
320001	Орон нутгийн төсвөөс	940,797.2	907,503.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	347,771.0	58,455.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,894.0	43,950.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,463.5	14,504.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	282,413.5	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	282,295.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	413,740.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	19
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	9	5
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,739.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,739.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,262.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268.63
210301	Гэрэл, цахилгаан	268.63
2104	Хангамж, бараа материалын зардал	2,762.66
210401	Бичиг хэрэг	-
210402	Тээвэр, шатахуун	1,563.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	559.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	805.00
210604	Урсгал засвар	805.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,170.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,255.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,255.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,477.19
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,477.19
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	10,982.73
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,494.46
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,244.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,244.78
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,660.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,584.78
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(4,494.46)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,494.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Иргэддээ тулгуурласан чадвартай хариуцлагатай нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлж иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх гүйцэтгэл үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо бүхий тасралтгүй суралцагч цомхон чадварлаг алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайланг хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан Соёлын төвүүд харьяалагдах яамдаасаа санхүүжилтээ авч, санхүүгийн тайлангаа яамдад нэгтгүүлдэг болсон. Нэгтгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 2022 оны байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэн өгсөн байна. Дээрх байгууллагуудын

байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

3.2.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,086,020.4 мянган төгрөгөөр буюу 74.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,155,899.0	879,295.1	(276,603.9)
Мөнгөн хөрөнгө	503,726.2	578,642.4	74,916.2
Авлага	230,874.9	97,598.8	(133,276.1)
Бараа материал	410,847.8	193,053.8	(217,794.0)
Үндсэн хөрөнгө	5,649,897.5	840,481.0	(4,809,416.5)
Нийт хөрөнгийн дүн	6,805,796.5	1,719,776.1	(5,086,020.4)
Нийт өр төлбөр	28,257.2	3,960.6	(24,296.6)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,777,539.3	1,715,815.5	(5,061,723.8)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,805,796.5	1,719,776.1	(5,086,020.4)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 74,916.2 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд зарцуулалт хийгээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 133,276.0 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн 30,967,1 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангийн 705.6 мянган төгрөг, Мал хамгаалах сангийн 1,209,4 мянган төгрөгийн авлага барагдуулалттай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 10,829.7 мянга, хандиваар 113,601.0 мянга, бусад эх үүсвэрээс 64,989.6 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч бүртгэсэн байна. Харин 5,522,883.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж, бүтцийн өөрчлөлтөөр 5,448,769.7 мянган төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,715,815.5 мянган төгрөг болж 5,061,723.8 мянган төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Ихбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,719,776.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,197.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,038.4 мянган төгрөгөөр тогтоосон.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 46,156.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлээ.

5.1.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын 2022 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 147.1 хувиар давж биелсэн боловч 13 нэр төрлийн орлого төвлөрүүлэхээс 8 нэр төрлийн орлого 46,156.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Өгсөн зөвлөмж: Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагд	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /маргсан, тэмдэглээгүй орхисон/,

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нуггийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
НИЙТ		6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 501,507,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 350,923.9 мянган төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 34,051.1 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 88,283.5 мянган төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага, 28,248.5 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 30.0 хувийг залруулагдаагүй, 70.0 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэрэн сумын ИТХ												
Дэрэн сумын ЗДТГ	5	16,893.7			5	16,893.7	5	16,893.7				
Дэрэн сумын СХС	1	631.0	1	631.0			1	631.0				
Дэрэн сумын ОНХС	2	321,707.1			2	321,707.1	2	321,707.1				
Дэрэн сумын БХС	2	5,442.0			2	5,442.0	2	5,442.0				
Дэрэн сумын МХС	1	6,250.0	1	6,250.0			1	6,250.0				
Дэрэн сумын ОННТ												
Дүн	11	350,923.8	2	6,881.0	9	344,042.8	11	350,923.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэрэн сумын ИТХ												
Дэрэн сумын ЗДТГ	6	8,283.8	-	-	4	8,114.2	2	169.6				
Дэрэн сумын СХС	1	24,384.8	1	24,384.8								
Дэрэн сумын ОНХС	2	67,400.0	1	8,000.0	1	59,400.0						
Дэрэн сумын БХС	2	10,172.10			1	143.8	1	10,028.3				
Дэрэн сумын МХС	2	18,676.20			1	625.6	1	18,050.6				
Дэрэн сумын ОННТ	-	-					0	-				
Дүн	13	128,916.90	2	32,384.80	7	68,283.6	4	28,248.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Дэрэн сумын ИТХ	-	-											
Дэрэн сумын ЗДТГ	1	-	-	-	1								
Дэрэн сумын СХС	-	-											
Дэрэн сумын ОНХС	-	-											
Дэрэн сумын БХС	-	-											
Дэрэн сумын МХС	-	-											
Дэрэн сумын ОННТ	-	-											
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Дэрэн сумын ИТХ	-	-	-	-	-								
Дэрэн сумын ЗДТГ	2	21,666.3	1	1,666.3	1	20,000.0							
Дэрэн сумын СХС	-	-											
Дэрэн сумын ОНХС	1	-			1	-							
Дэрэн сумын БХС	-	-											
Дэрэн сумын МХС	-	-											
Дэрэн сумын ОННТ	1	46,156.4					1	46,156.4					
Дүн	4	67,822.7	1	1,666.3	2	20,000.0	1	46,156.4	-	-	-	-	-
Нийт дүн	5	67,822.7	1	1,666.3	3	20,000.0	1	46,156.4	-	-	-	-	-